



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх,
сонгуулийн явцыг ажиглах төрийн бус байгууллагыг
бүртгэх тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 107 дугаар зүйлийн 107.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Сонгуулийн Ерөнхий Хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн үйл ажиллагааны үеэр хэвлэл мэдээллийн байгууллагууд, сонгуулийн автоматжуулсан системийн үйл ажиллагаанд болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтэд ажиглалт, хяналт шинжилгээ хийхээр бүртгүүлэх хүсэлтээ ирүүлсэн Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ /Нээлттэй нийгэм форум ТББ, Глоб Интернэшнл ТББ, МИДАС ТББ, Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд ТББ, Захиргааны шинэ санаачлага ТББ, Бодлогод залуусын хяналт ТББ/ төрийн бус байгууллагад сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, ажиглалт хийхийг зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, сонгуулийн үйл явцыг ажиглах төрийн бус байгууллагыг үйл ажиллагаагаа явуулахад нь холбогдох хууль, журамд заасны дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны сонгуулийн хороодод даалгасугай.

3. Сонгуулийн хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн, Ёс зүйн дүрмээ баримтлан ажиллахыг Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний удирдлагад үүрэг болгосугай.

ДАРГА 2. Содномцэрэн Ч.СОДНОМЦЭРЭН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ц.БОЛДСАЙХАН



0 0 0 0 8 1